



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТИН АЛБА
ДОТООД АУДИТИН НЭГЖ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТИН АЖЛЫН ТАЙЛАН

ЧОЙБАЛСАН ХОТ

2016 ОН



ДОРНОД АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 05-01-64

Чойбалсан хот

Хяналт шалгалтын дүнгийн тухай

Нэг.Хяналт шалгалтын зорилго.

1.1. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг үндэслэн Дорнод аймгийн Засаг даргын баталсан 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01 тоот удирдамжийн дагуу Баянтүмэн сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргын нөөцийн сангийн 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны санхүүгийн баримтанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Гэрэл би Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр шалгагдсан тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд хяналт шалгалтын зорилгыг чиглүүлж ажиллав.

1.2.Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Баянтүмэн сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргын нөөцийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Гэрэл 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

1.3.Хяналт шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл, танилцуулга, өмнөх шалгалтын түүхээс

Баянтүмэн сумын Засаг даргын тамгын газар нь 770001023 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 9029435 тоот регистрийн дугаартай, Төрийн сангийн 070255001, нэмэлт санхүүжилтийн 070255402 тоот төгрөгийн данстайгаар, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох **Нэг цэгийн**

үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Засаг даргын тамгын газрын шалгалтанд хамрагдсан хугацааны харилцах данс, хөрөнгө мөнгө захиран зарцуулалтын байдлыг авч үзвэл 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Мөнхнаран, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Сарандагина, С.Чулуун-Эрдэнэ нар зурж ирсэн байна.

-Өмнөх шалгалтын талаар.

Баянтумэн сумын Засаг даргын Тамгын газрын 2015 оны санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Хоёр.Хяналт шалгалтын цар хүрээ, хамрагдсан асуудлууд.

2.1. Санхүүгийн хяналт шалгалтад Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал шийдвэр, 2015 оны касс, харилцах болон материалын тайлан, өр авлагын байдал, улирал жилийн эцсийн тайлан тэнцэл бусад холбогдох санхүүгийн баримтууд хамрагдлаа.

2.2.Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийхэд:

2015 онд Баянтумэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 15 тоот тогтоолоор Засаг даргын Тамгын газрын төсвийг 221599.2 мянган төгрөг, Багийн засаг даргын ажлын албаны төсвийг 40053.0 мянган төгрөг, Засаг даргын нөөцийн сангийн төсвийг 7000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант хугацаанд сумын ИТХ-аар доорхи төсвийн тодотголууд хийгдсэн байна. 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар хуралдааны 01 тоот тогтоолоор Засаг даргын Тамгын газрын төсвийг 224519.2 мянган төгрөг, Багийн засаг даргын ажлын албаны төсвийг 42986.0 мянган төгрөг, Засаг даргын нөөцийн сангийн төсвийг 7000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан ба 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 13 дугаар хуралдааны 12 тоот тогтоолоор Засаг даргын Тамгын газрын төсвийг 242552.2 мянган төгрөг, Багийн засаг даргын ажлын албаны төсвийг 46296.0 мянган төгрөг, Засаг даргын нөөцийн сангийн төсвийг 17657.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна. 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дугаар хуралдааны 16 тоот тогтоолоор Засаг даргын Тамгын газрын төсвийг 242552.2 мянган төгрөг, Багийн засаг даргын ажлын албаны төсвийг 46296.0 мянган төгрөг, Засаг даргын нөөцийн сангийн төсвийг 17657.0 мянган төгрөгөөр

баталсан нь Засаг даргын Тамгын газрын төсвийг 20953.0 мянган төгрөгөөр, Багийн ЗД-ын ажлын албаны төсвийг 6243.0 мянган төгрөгөөр, ЗДНС-гийн төсвийг 10657.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

2015 онд 306505.2 мянган төгрөгийн зардлын төсөв батлагдсанаас 286433.8 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 20071.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Зардлын зүйлээр авч үзвэл: цалингийн зардлыг 1940.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 54.0 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 12.4 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 856.7 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 458.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 3320.6 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 283.9 мянган төгрөгөөр, ном хэвлэл худалдан авах зардлыг 126.0 мянган төгрөгөөр, сургалт семнарын зардлыг 920.0 мянган төгрөгөөр, зөвлөн эдлэл нормын хувцасны зардлыг 150.0 мянган төгрөгөөр, жижиг эд хогшил худалдан авах зардлыг 146.5 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийн зардлыг 774.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 8460.8 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 666.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг 549.9 мянган төгрөгөөр, болзошгүй эрсдлийг нөхөх зардлыг 1351.0 нийт 20071.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

-Нэмэлт төсвийн санхүүжилтийн талаар:

2015 онд Хүнс, хөдөө аж ахуйн газраас тарилгын хөлс 65468.6 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардал 1513.0 мянган төгрөг, А/155 тоот захирамжаар түймрийн хохиролд 5471.5 мянган төгрөг, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаас 47200.0 мянган төгрөг, Хөдөлмөрийн хэлтсээс 2400.0 мянган төгрөг, сумын Засаг даргын Тамгын газраас 6423.4 мянган төгрөг, түймэрийн хохирол 1196.0 мянган төгрөг, бусад орлого 1000.0 мянган төгрөг нийт 130672.5 мянган төгрөгийн орлоготой байна.

-Засаг даргын нөөцийн сан:

Засаг даргын нөөцийн сангийн 2015 оны зардлыг ангилвал: 30.0 хувь буюу 5035.3 мянган төгрөгийг түймрийн зардалд, 15.4 хувь буюу 2549.4 мянган төгрөгийг мал тооллогын зардалд, 1.2 хувь буюу 200.0 мянган төгрөгийг цэрэг татлагын зардалд, 11.6 хувь буюу 1860.0 мянган төгрөгийг гоц халдварт цэцэг өвчин, 41.8 хувь буюу 6948.9 мянган төгрөгийг болзошгүй зардалд зарцуулсан байна.

-Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтын байдал, тооллого үнэн зөв чанартай хийгдсэн эсэх:

2015 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Мянганы зам" 225791.3 мянган төгрөг, 3 дугаар багийн хүүхэд залуучуудын төв 49888.4 мянган төгрөг нийт 275679.7 мянган төгрөгийн хөрөнгийг барилга байгууламж болон батлан хамгаалах

тоног төхөөрөмж дансанд орлого авсан байна. Мөн биет бус дансанд бүртгэлтэй байсан 244.5 мянган төгрөгийн үнэ бүхий гагнуурын аппаратыг тавилга эд хогшил данс руу шилжүүлсэн байна.

-Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх.

Санхүү, төсвийг зохистой удирдаагүйгээс 2015 оны жилийн эцэст 12076.9 мянган төгрөгийн өглөгтэйгээр тайлагнасан ба 4.9 хувь буюу 598.7 мянган төгрөг нь бичиг хэргийн өглөг, 2 хувь буюу 238.7 мянган төгрөг нь түлш халаалтын өглөг, 6.6 хувь буюу 798.3 мянган төгрөг нь тээвэр шатахууны өглөг, 3.4 хувь буюу 413.7 мянган төгрөг нь томилолтын өглөг, 28.6 хувь буюу 3443.4 мянган төгрөг нь байгууллагад өгөх өглөг, 54.5 хувь буюу 6584.1 мянган төгрөг нь хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

Гурав.Хяналт шалгалтын үр дүн.

3.1.Хяналт шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудлууд

Шалгалтын хугацаанд тус Засаг даргын тамгын газрын дарга, няглан бодогч нарт хяналт шалгалтын явцыг танилцуулан ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалтыг үндэслэн 3857.0 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 4 акт тогтоож, 1659.2 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага хүргүүллээ.

3.2.Шалгуулагчийн ололттой, дэвшилттэй тал

Баянтүмэн сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц сангийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газарын харьяа Дорнод аймгийн Аудитын газраас “Баянтүмэн сумын Засаг даргын Тамгын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв шударга илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэлт өгсөн байна.

3.3.Шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн асуудал, зөрчил, дутагдал, гарсан шалтгаан

Санхүү, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ.

1. Засаг даргын нөөц сангаас урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахыг журамласан байхад тус сумын Засаг дарга урьдчилан төлөвлөх боломжтой 1659.2 мянган төгрөгийн зардлуудыг санхүүжүүлсэн, мөн уг зардлууд төсөв гүйцэтгэлийн тайлан байхгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчсөн байна.

2. Засаг даргын 2015 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/106 тоот захирамжаар сумын сумын Эрүүл мэндийн төвийн ойн үйл ажиллагаанд 1500.0 /нэг сая таван зуун мянга/ мянган төгрөгийн хандив өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 25.10 дахь заалт “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив тусlamж өгөхийг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5.1-д заасан ”энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Засаг даргын 2015 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/105 тоот захирамжаар сумын Засаг даргын Тамгын газрын даргад цэргийн дүрэмт хувцас 900.0 /есөн зуун мянга/ мянган төгрөгөөр худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5.1-д заасан ”энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр заалтын 1.2.4-д “төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь статисик мэдээлэл гаргах ажлыг хариуцна.” гэж заасныг зөрчиж Санхүүгийн албаны дарга А.Баатарсүхэд 2015 оны 1, 2 дугаар саруудад үндсэн цалингийн 20 хувиар тооцож 251.3 /хоёр зуун тавин нэгэн мянга гурван зуу/ мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна

5. 2015 онд Баянтумэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Ж.Мөнхнаранд “нууцын нэмэгдэл” гэж 1205.7 /нэг сая хоёр зуун таван мянга долоон

зуу/ мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д заасан “төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс”-бүрдэнэ., төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна

3.4.Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт, тайлбар.

/хавсралтаар/

Дөрөв. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал.

Шалгалтын хугацаанд тус Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт хяналт шалгалтын явцыг танилцуулан ажиллалаа.

1.Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагааг шалгах 7.2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 23.0 хувь буюу “бага”, Засаг даргын нөөцийн сангийн санхүүгийн үйл ажиллагааг шалгах 7.2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 23.0 хувь буюу “бага” эрсдэлтэй гэж үнэлэгдлээ.

2.Тус Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэхэд: Улсын ахлах байцаагчийн 4 актаар 3857.0 мянган төгрөг, 1 албан шаардлагаар 1659.2 мянган төгрөг нийт 5516.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнийг зөрчлийн ангилалаар авч үзвэл: зориулт бусаар зарцуулсан 4059.2 мянган төгрөг буюу 73.6 хувь, дутуу болон илүү олгосон цалин хөлс 1457.0 мянган төгрөг буюу 26.4 хувийг эзэлж байна.

Баянтүмэн сумын Засаг даргад:

1.Төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, өр авлага үүсгэхгүй байх, үйлчилгээний стандарт тоо, хэмжээ, чанар хүртээмжийг бууруулахгүй байх, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах үүднээс Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7-д заасны дагуу тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлан орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д заасан “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.4-д заасан “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн

бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах” гэсэн заалтын дагуу төсвийг бодитой тодорхойлж, оновчтой хувиарлах.

3.Төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын хууль, эрх зүйн мэдлэг боловсрол, чадварын түвшинг сайжруулах, түүнчлэн Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрэм”-ийн 8-д заасны дагуу эд хариуцагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэлийн болон бусад стандарт программ дээр ажиллаж сургах.

Баянтумэн сумын Төрийн сангийн төлөөлөгчид :

Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.4-д заасан “Төрийн сан төсвийн байгууллагын ирүүлсэн төлбөрийн хүсэлтийг холбогдох цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнгээр хийж гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана” гэсэн заалтын дагуу шаардлага хангаагүй гүйлгээг хийж гүйцэтгэхгүй байх.

Баянтумэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад:

1.Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, актаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь барагдуулах, өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг 100 хувь хангагдах хүртэл улирал тутам Санхүүгийн хяналт, аудитын албанд тайлagnаж байх.

2.Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д заасан “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.4-д заасан “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах” гэсэн заалтуудын дагуу төсвийг бодитой тодорхойлох, тухайн төсвийн жилийн хязгаарт багтаан санхүүжилтийг зарцуулах талаар ажилтан, албан хаагчдаа бодлогын зөвлөмжөөр хангаж ажиллах.

3.Төсвийн тухай хууль тогтоомжийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах.Тухайлбал:Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлсэн, төсвийн хүрээнд зардал гаргалгүй хөрөнгө бэлтгэх, урсгал засвар хийх нэрээр өглөгийг үүсгэх, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулах, элэгдлийн хугацаа дуусгавар болоогүй байхад дур мэдэн тавилга, эд хогшил худалдан авсан, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлолгүйгээр тоног төхөөрөмж худалдан авахыг зогсоох гэх мэт.

4. Дотоод хяналтыг эрсдэлтэй нэгж дээр төвлөрүүлэн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллах. Тухайлбал: Төсвийн эрсдэл үүсэх нөхцлийг бүрдүүлсэн, төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, өр авлага үүсгэхгүй байх, үйлчилгээний стандарт тоо, хэмжээ, чанар хүртээмжийг бууруулахгүй байх, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр эрсдлийн судалгаа, тооцоолол хийх гэх мэт.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Т.ГЭРЭЛ



ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Ж.МОНХНАРАН

Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт №1

Іалгасан: Санхүүгийн хяналт, аудитын а.

Т.Гэрэл

/Хяналт шалгалтын улсын ахлах байцаагч/

Баянтүмэн сум ЗДТГ, ЗД-ын нөөцийн сан

2016 оны 12 дугаар сарын 21